



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 08

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3, Ир-эдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны байцаагч Ш.Мөнхжаргалаас Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдлийг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Энхтуяа

-Аудитын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:


А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Б.Ариундэлгэр

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж, дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 06 дугаар сарын 28-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Аудитын газрын дарга /Ч.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ө.СУВДАА